“ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/22 дугаар тогтоолоор “Дулааны тавдугаар цахилгаан станц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг баталсан. Улмаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор дүрэмд өөрчлөлт оруулж, үүнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/181 дүгээр захирамжаар байгууллагын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Захирамжийн дагуу тус байгууллага нь Техник хяналтын хэлтэс, Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/12 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Хөдөлмөрийн дотоод журмыг, 2 дугаар хавсралтаар Цалин хөлсний журмыг, мөн өдрийн А/13 дугаар тушаалаар Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг, 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/53 дугаар тушаалаар Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг, мөн өдрийн А/54 дүгээр тушаалаар Ёс зүйн дүрмийг, 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/12 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, нэмэгдэл, урамшуулал олгох журмыг тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу холбогдох инженер ажилтнуудыг ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр ханган ажиллаж байна.

Мөн хуулийн дагуу эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулж байна.


Түүнчлэн ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх хүрээнд шаардлагатай техник хэрэгсэл, төхөөрөмжөөр тухай бүр ханган ажиллаж байна.

Мөн байгууллагын нийт ажилтнуудаас саналыг авч, хамгийн олон санал авсан 3 хүнийг газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүнээр сонгон ажиллуулж байна.


Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Шилэн дансны тухай хууль, журмын хүрээнд холбогдох мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Байгууллагаас ажилтнуудыг чадавхжуулах хүрээнд холбогдох чиглэлүүдээр дараах сургалтуудад хамруулаад байна:

1. 01 дүгээр сарын 28-ны өдөр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад зориулсан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан сургалтад Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга хамрагдав.



2. 03 дугаар сарын 10-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Төрийн цахим үйлчилгээний газраас хамтран зохион байгуулсан ил тод байдлын сургалтад Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга хамрагдав.



3. 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх” сургалтад Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэн хамрагдав.

4. 03 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Байгууллагын стратегийн төлөвлөлт ба тэнцвэржүүлсэн үнэлгээний картыг нэвтрүүлэх нь” сургалтад Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга хамрагдав.






5. 04 дүгээр сарын 06-ны өдөр Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан архив, албан хэрэг хөтлөлтийн eDoc систем шинэчлэгдсэнтэй холбоотой сургалтад Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэн хамрагдав.


6. 05 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал” сэдэвт сургалтад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын ахлах инженер хамрагдав.



7. 05 дугаар сарын 27-ны өдөр төсөлд ашиглагдах DJI Enterprise мэргэжлийн дроны сургалтад холбогдох инженерүүд хамрагдав. Сургалтын хүрээнд DJI мэргэжлийн дроны үндсэн ажиллагаа; Аюулгүй нислэг ба зөв төлөвлөлт; Зураглал, өгөгдөл цуглуулалт; Ухаалаг нислэг, зураг боловсруулах программ болон төслийн орчинд ашиглах практик дадлага зэрэгт суралцав.




8. 06 дугаар сарын 25-ны өдөр нийслэлийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Ёс зүйн хороотой хамтран зохион байгуулсан сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүд хамрагдав.



9. Байгууллагын инженер техникийн ажилтнуудад зориулан ачаа өргөх, зөөх машины аюулгүй ажиллагаанд хяналт тавих чиглэлээр тусгай эрх олгох сургалтыг 07 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулав.

10. Байгууллагын инженер техникийн ажилтнуудад зориулан эрсдэлтэй ажлын байрны чиглэлээр холбогдох сургалтыг 09 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулав.

11. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 09 дүгээр 21-ний өдөр сургалт зохион байгуулснаас байгууллагын холбогдох ажилтан оролцов.



12. Байгууллагын үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдөх захирамжлалын, зохион байгуулалтын баримт бичгийг кирилл болон үндэсний монгол бичгээр зохион бүрдүүлж, баримтжуулахтай холбоотойгоор ажилтнуудад үндэсний монгол бичгийн сургалтыг 09 дүгээр сараас эхлэн зохион байгуулж байна.



“ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ОНӨААТҮГ

2026.09.28